



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Монголын хүүхдийн спортын  
зуны VIII наадмын зохион байгуулах хороо,  
нэгдсэн заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 30.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам"-ын 2.1 дэх заалтын 4, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын хамтарсан "Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам"-ыг батлах тухай 2024 оны А/237, А/76, А/604 дүгээр тушаалыг тус тус үндэслэн тушаах нь:

1."Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам"-ын Зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, дэд ажлын хэсгийг хоёрдугаар, нэгдсэн зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Наадмын зохион байгуулалтыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (О.Гэрэл)-т, Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Ж.Баасансүрэн)-т тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (О.Баттулга)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Э.БИЛЭГТ



142510204

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 03 дугаар сарын 17 өдрийн А/УС... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ЗУНЫ СПОРТЫН VIII НААДМЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Биеийн тамир, спортын улсын хорооны Бодлого төлөвлөлтийн газрын дарга О.Гэрэл
- Гишүүд:
- Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн
  - Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга О.Баасан
  - Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Д.Цэрэнболд
  - Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга Б.Эрдэнэваанчиг
  - Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн М.Наранбадрах
  - Биеийн тамир, спортын улсын хорооны Гадаад харилцаа, мэдээлэл технологийн ахлах мэргэжилтэн Б.Лхагваням
  - Монголын үндэсний олон нийтийн радио телевизийн Спорт сувгийн ерөнхий продюсер О.Ууганбаяр (зөвшилцсөнөөр)
  - Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч С.Саранцэцэг
  - Нийслэлийн цагдаагийн удирдах газар /зөвшөлцсөнөөр/
  - Нийслэлийн Эрүүл мэндийн төв /зөвшөлцсөнөөр/
  - Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Д.Алтанхуяг
  - Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Г.Батбаяр
  - Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Т.Уранчимэг
  - Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Р.Очирпүрэв

Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга  
Б.Мөнх-Эрдэнэ

Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга  
Р.Сосорбарам

Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга  
Д.Мөнхбаяр

Нарийн бичгийн дарга: Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын  
бодлогын хэрэгжилтийн хэлтсийн  
мэргэжилтэн Э.Хүрэлчулуун

Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын  
бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн  
Д.Мөнхбаяр

---o0o---

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны 02 дугаар сарын 17 өдрийн  
01/45 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ЗУНЫ СПОРТЫН VIII НААДМЫН  
ШИГШЭЭ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ДЭД АЖЛЫН  
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Наадмын нэгдсэн арга хэмжээ, шигшээ тэмцээний зохион байгуулалт, мандат олголт, баталгаажилт, заал, талбай, танхим болон тохижилт, нийтлэг үйлчилгээг спортын холбоодын үйл ажиллагаа хариуцсан дэд ажлын хэсэг

Ахлагч: Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн

Гишүүд: Биеийн тамир, спортын улсын хорооны Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Мэнджаргал

Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн М.Наранбадрах

Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн Э.Хүрэлчулуун

Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхбаяр

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Саранцэцэг

Төв аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга Д.Алтанхуяг

Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Г.Батбаяр

Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Т.Уранчимэг

Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Р.Очирпүрэв

Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Б.Мөнх-Эрдэнэ

Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Ц.Сосорбарам

Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Д.Мөнхбаяр

Спортын холбоодын ерөнхий нарийн бичгийн дарга нар

2. Наадмын сурталчилгаа, веб сайт, цахим бүртгэл, статистик, тэмцээний мэдээлэл оруулалт, шагнал гардуулалт, сайн дурын ажилтны үйл ажиллагааг хариуцсан дэд ажлын хэсэг

Ахлагч: Биеийн тамир, спортын улсын хорооны Гадаад харилцаа, мэдээлэл технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат

Гишүүд: Биеийн тамир, спортын улсын хорооны Гадаад харилцаа, мэдээлэл технологийн ахлах мэргэжилтэн Б.Лхагваням

Биеийн тамир, спортын улсын хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Я.Гомбодорж

Биеийн тамир, спортын улсын хорооны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн Д.Жавхлан

Биеийн тамир, спортын улсын хорооны Гадаад харилцаа, мэдээлэл технологийн мэргэжилтэн Ө.Номуун

3. Эмнэлгийн тусламж үйлчилгээ, түргэн тусламжийн үйлчилгээг тэмцээний үеийн орчны эрүүл ахуй хариуцсан дэд ажлын хэсэг

Ахлагч: Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн дарга Б.Эрдэнэваанчиг

Гишүүд: Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн албаны дарга М.Булган

Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн эмч нар

Спортын холбоодын тэмцээний үед ажиллах эмч шүүгчид

---oOo---

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын  
2025 оны 03 дугаар сарын 17 -ны өдрийн  
11/4 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



## МОНГОЛЫН ХҮҮХДИЙН СПОРТЫН ЗУНЫ VIII НААДМЫН НЭГДСЭН ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Биеийн тамир, спортын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, 30.3 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.8 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1 дэх заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл урлагийн газар, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын хамтарсан 2024 оны А/237, А/76, А/604 дүгээр тушаалаар батлагдсан “Соёл, спортын ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”-ын хэрэгжилтийг хангасан байна.

### Хоёр. Зорилго

2.1. Наадам нь зуны спортын төрлийг сурталчлах, өсвөр үеийнхний бие бялдрыг хөгжүүлэх, хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, тив, дэлхийн тэмцээнд өрсөлдөх тамирчдын залгамж халааг бэлтгэхэд Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын (цаашид наадам гэх) зорилго оршино.

### Гурав. Наадмын удирдлага, зохион байгуулалт

3.1. Наадмыг улсын хэмжээнд ерөнхий зохицуулалтаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо хангаж, наадмын Зохион байгуулах хороог байгуулж, нэгдсэн зааврыг удирдлага болгон хэрэгжүүлнэ.

3.2. Наадмын Зохион байгуулах хорооны бүрэлдэхүүн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо, Дүүргийн биеийн тамир, спортын хороо, спортын холбоодын төлөөллөөс бүрдэнэ.

3.3. Зохион байгуулах хороо нь наадамд оролцогчдыг Биеийн тамир, спортын цахим систем (сpanel.sport.gov.mn)-ийг нээх, хаах зөвшөөрөл олгоно.

3.4. Аймаг, дүүрэгт наадмын Зохион байгуулах салбар хороог байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган наадмын анхан шат, шигшээ тэмцээнд баг тамирчдыг бэлтгэн оролцуулна.

3.5. Биеийн тамир, спортын улсын хорооны цахим бүртгэл хариуцсан нэгж нь наадамд оролцогчдыг бүртгэх админы эрхийг эзэмшиж, мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулна.

3.6. Зохион байгуулах хороо нь наадмын талаарх бүхий л мэдээллийг [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) цахим мэдээллийн сангийн тэмцээн, наадмын системд байршуулна.

3.7. Наадмын шигшээ тэмцээний үр дүнг [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) цахим мэдээллийн сангийн тэмцээн, наадмын системд 24 цагийн дотор оруулна.

3.8. Наадмын шигшээ тэмцээний зохион байгуулалтын зардал, шагнал урамшуулал болон бусад шаардагдах зардлыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо хариуцна.

Дөрөв. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын хүлээх үүрэг

4.1. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага нь наадмын анхан шатны тэмцээнийг зааварт тусгагдсан спортын төрөл, жин, зай, ангиллаар зохион байгуулна.

4.2. Анхан шатны тэмцээнээс шалгарсан тамирчдыг наадмын шигшээ тэмцээнд оролцуулахад шаардагдах томилолт, хоол, байр, унааны зардлыг бүрэн хариуцна.

4.3. Наадмын цахим бүртгэл хариуцсан ажилтныг тусгайлан томилж ажиллуулах үүрэгтэй.

4.4. Наадамд оролцох баг тамирчдын спортын төрөл тус бүрд заасан насны хязгаарыг хатуу баримтлах үүрэгтэй.

4.5. Наадамд оролцох баг, тамирчдыг анхан шатны тэмцээнд Засаг захиргааны нэгж, харьяалал, спортын клубийн нэрээр нэгдсэн зааврын дагуу Биеийн тамир, спортын цахим систем (сpanel.sport.gov.mn)-д бүртгэж, шалгарсан тамирчдыг шигшээ тэмцээнд баталгаажуулж оролцуулах үүрэгтэй.

4.6. Наадмын анхан шатны тэмцээний үр дүн тайлан, шигшээ тэмцээнд оролцох тамирчдын тоон болон нэрэн мэдүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн дотор Зохион байгуулах хороонд info@sport.gov.mn хаягаар ирүүлнэ.

4.7. Наадмын шигшээ тэмцээнд оролцох тамирчдыг үдэн гаргах, угтан авах үйл ажиллагааг зохион байгуулж, наадмын явцын мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлж, түгээн сурталчилна.

4.8. Баг, тамирчдыг тэмцээний өдрүүдэд дэх гэнэтийн ослын болон бусад холбогдох даатгалд харьяалах байгууллагын зүгээс зайлшгүй хамруулж даатгуулах үүрэгтэй.

4.9. Наадмын шигшээ тэмцээний нээлт, хаалтын ажиллагаанд оролцох байгууллага нь лого бүхий тугийг барьж жагсана.

4.10. Наадмын нэгдсэн зааварт тусгагдсан тамирчны насны хязгаарыг санаатай болон санаандгүй зөрчиж (сpanel.sport.gov.mn) цахим системд буруу мэдээлэл оруулсан нь тогтоогдвол тухайн байгууллагын удирдлагад Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтыг үндэслэн хариуцлага тооцох үндэслэл болно.

#### Тав. Спортын холбоодын үүрэг, хариуцлага

5.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороо нь наадмын хөтөлбөрт багтсан спортын холбоодтой Ажил гүйцэтгэх гэрээ байгуулна.

5.2. Спортын холбоод нь тухайн төрлийн шигшээ тэмцээний хөтөлбөр, бэлтгэл ажил, тэмцээн болох заал, танхим, талбайн тохижилт, тамирчдын аюулгүй байдал, шаардагдах спортын хэрэгсэл, хэрэглэл материал, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, нөөц хангамж, хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, нээлт, хаалт, шагнал гардуулалд, хүний нөөц зэрэг бусад зохион байгуулалтын ажлыг бүрэн хариуцах үүрэг хүлээнэ.

5.3. Спортын холбоод нь тухайн төрлийн шигшээ тэмцээнийг шүүн явуулах Шүүгчийн зөвлөлийг томилж, баталгаажуулан Зохион байгуулах хороонд тэмцээн эхлэхээс ажлын 5 хоногийн өмнө ирүүлсэн байна. Шүүгчийн зөвлөл нь тухайн спортын төрлийн техникийн зөвлөгөөнийг удирдана.

5.4. Монголын диф спортын хороо, Монголын тусгай олимпын хороо, паралимпийн спортын холбоо нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрөлд оролцогч тамирчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, ангиллыг баталгаажуулах үүрэг хүлээнэ.

5.5. Спортын төрлийн тэмцээн зохиогдох заал, танхим, талбайд эмч шүүгч ажиллуулж, тамирчдыг бие халаалт хийх нөхцөл боломжоор ханган ажиллана.

5.6. Наадмын үзүүлэх тоглолтод сонгогдсон спортын холбоод нь тухайн шаардагдах зардлыг бүрэн хариуцна.

## Зургаа. Наадмын үе шат, хугацаа, спортын төрөл

6.1. Наадмыг зуны спортын үндсэн 22, үзүүлэх тоглолт 4, хөгжлийн бэрхшээлтэй спортын 7 төрлийн зай, ангиллаар хоёр үе шаттайгаар "Мөрөөдлийнхөө төлөө шударгаар өрсөлдье" уриатай зохион байгуулна.

6.1.1. Анхан шатны тэмцээн (Аймаг, дүүрэг)

2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс өмнө зохион байгуулсан байна.

6.1.2. Шигшээ тэмцээн (Улс)

2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 05-нд зохион байгуулна.

6.1.3. Наадмын шигшээ тэмцээний нээлт 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр, хаалт 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулна.

6.2. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрлүүд: Үүнд

6.2.1. Үндсэн төрөл:

- |                  |                       |
|------------------|-----------------------|
| 1. Байт харваа   | 12. Сагсан бөмбөг 5x5 |
| 2. Бокс          | 13. Сагсан бөмбөг 3x3 |
| 3. Буудлага      | 14. Самбо бөх         |
| 4. Бадминтон     | 15. Таеквондо         |
| 5. Волейбол      | 16. Усанд сэлэлт      |
| 6. Бүжгийн спорт | 17. Хөл бөмбөг        |
| 7. Гимнастик     | 18. Хөнгөн атлетик    |
| 8. Даам          | 19. Хүндийн өргөлт    |
| 9. Дугуй         | 20. Чөлөөт бөх        |
| 10. Жүдо бөх     | 21. Шатар             |
| 11. Жюү жицу     | 22. Ширээний теннис   |

6.2.2. Үзүүлэх тоглолт:

1. Электрон спорт /Valorant 5vs5/
2. Холимог тулаан

3. Модон барилдаан
4. Дуатлон

6.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрөл:

1. Пара бочи
2. Пара хөнгөн атлетик
3. Хонхот бөмбөг
4. Диф сагсан бөмбөг 3x3
5. Диф даам
6. Тусгай хөнгөн атлетик
7. Тусгай хамтарсан хөл бөмбөг

6.3. Наадмын спортын төрлийн зай, ангилал, оролцох тамирчны насны хязгаар, тамирчны тоо, зохиогдох хугацаа:

6.3.1. Наадмын нэгдсэн зааварт орсон спортын төрлийн тэмцээний төрөл, зай, жин, ангиллыг тухайн спортын төрлийн олон улсын дүрэм, журмын дагуу спортын холбоодтой зөвшилцөн тусгасан болно.

6.3.2. Наадмын шигшээ тэмцээнд 1 тамирчин 1 спортын төрөлд оролцох ба сонгосон спортын төрлийн зай, ангилалд давхцан оролцож болно.

6.3.3. Үндсэн спортын төрөл

№	Спортын төрөл	Ангилал	Тэмцээний зай, тоо, насны хязгаар	Насны ангилал /он, сар, өдөр/	Шигшээ тэмцээнд оролцох тамирчдын тоо, хугацаа (ангилал тус бүрд)
1	Байт харваа	Ганцаарчилсан 60м	14-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2011.12.31	Анхан шатны тэмцээнээс 1-р байр эзэлсэн баг, тамирчин оролцоно.
		Холимог хос 60м			
		Баг 60м	14-17 нас: Охид 3 Хөвгүүд 3		
2	Бокс	44кг, 46кг, 48кг, 50кг, 52кг, 54кг, 57кг, 60кг, 63кг, 66кг, +66кг	15-16 нас: Хөвгүүд	2009.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		44кг, 46кг, 48кг, 50кг, 52кг, 54кг, 57кг, 60кг, 63кг, +63кг	Охид		
3	Буудлага	Хийн урт буу 10м	13-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2012.12.31	Анхан шатны тэмцээнээс 1-р байр эзэлсэн баг, тамирчин оролцоно.
		Хийн гар буу 10м			
		Холимог хос хийн урт буу 10м			
		Холимог хос хийн гар буу 10м			
4	Бадминтон	Ганцаарчилсан	14-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2011.12.31	Анхан шатны тэмцээнээс 1-р байр эзэлсэн баг, тамирчин оролцоно.
		Дан хос	14-17 нас: Охид 2 Хөвгүүд 2		
		Холимог хос	14-17 нас: Охид Хөвгүүд		
5	Волейбол	Баг	15-17 нас: Охид 12 Хөвгүүд 12	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс шалгарсан 1 баг оролцоно.
6	Гимнастик	Спортын гимнастик ганцаарчилсан	15 нас хүртэлх: Охид (2 хэрэглэл)	2010.12.31	Анхан шатны тэмцээнээс 1-р байр эзэлсэн баг, тамирчин оролцоно.
			16 нас хүртэлх: Хөвгүүд (3 хэрэглэл)	2009.12.31	
		Спортын гимнастик багийн төрөл	9-12 нас: Охид 5	2013.01.01 2016.12.31	
			12-15 нас Хөвгүүд 5	2010.01.01 2013.12.31	
		Аэробик гимнастик ганцаарчилсан	12-14 нас: Охид Хөвгүүд	2011.01.01 2013.12.31	
		Аэробик гимнастик багийн төрөл	12-14 нас: Хүйс харгалзахгүй 8		

7	Даам	100 буудалт даам	13 нас хүртэлх: Охид Хөвгүүд	2012.12.31	Анхан шатны тэмцээнээс төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.	
			14-17 нас: Охид Хөвгүүд	2009.01.01 2011.12.31		
8	Дугуй	Уулын бартаат замын уралдаан	13-14 нас: Охид 10км Хөвгүүд 20км	2011.01.01 2012.12.31	Анхан шатны тэмцээнээс төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.	
		Уулын марафон уралдаан	15-16 нас: Охид 30км Хөвгүүд 50км	2009.01.01 2010.12.31		
9	Жүдо бөх	50кг, 55кг, 60кг, 66кг, 73кг, 81кг, -90кг, +90кг	15-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.	
		40кг, 44кг, 48кг, 52кг, 57кг, 63кг, -70кг, +70кг	Охид			
10	Усанд сэлэлт	Өврөөр даллах сэлэлт 100м	15-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс зай тус бүрд 1-р байр эзэлсэн баг, тамирчин оролцоно.	
		Өврөөр даллах сэлэлт 200м				
		Араар даллах сэлэлт 100м				
		Араар даллах сэлэлт 200м				
		Мэлхий сэлэлт 100м				
		Мэлхий сэлэлт 200м				
		Эрвээхэй сэлэлт 100м				
		Эрвээхэй сэлэлт 200м				
		Буухиа 4x100м /өврөөр даллах сэлэлт				15-17 нас: Охид 4 Хөвгүүд 4
		Холимог буухиа 4x100м				15-17 нас: Охид 2 Хөвгүүд 2
11	Сагсан бөмбөг 5x5	Баг:	15-17 нас: Охид 12 Хөвгүүд 12	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс шалгарсан 1 баг оролцоно.	
12	Сагсан бөмбөг 3x3	Баг:	15-17 нас: Охид 4 Хөвгүүд 4			
13	Самбо бөх	46кг, 49кг, 53кг, 58кг, 64кг, 71кг, 79кг, 88кг, +88кг	15-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.	
		41кг, 44кг, 47кг, 50кг, 54кг, 59кг, 65кг, 72кг, +72кг	Охид			

14	Бүжгийн спорт	Хос стандарт бүжиг	14-17 нас Охид Хөвгүүд	2008.01.01 2011.12.31	Анхан шатны тэмцээнээс төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн баг, тамирчин оролцоно. Стандарт - 5 бүжиг (УВ,Т,ВВ,Уф,ХФ), Латин-5 бүжиг (С,Ч,Р,П,Ж)
		Хос латин бүжиг			
		Соло стандарт бүжиг	14-17 нас: Охид		
		Соло латин бүжиг			
15	Шатар	Ганцаарчилсан	12 нас хүртэлх: Охид Хөвгүүд	2013.01.01	Анхан шатны тэмцээнээс төрөл тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
			13-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2012.12.31	
16	Таеквондо	45кг, 48кг, 51кг, 55кг, 59кг, 63кг, 68кг, 73кг, 78кг, +78кг	15-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		42кг, 44кг, 46кг, 49кг, 52кг, 55кг, 59кг, 63кг, 68кг, +68кг	Охид		
17	Хөлбөмбөг	Баг	14-15 нас: Охид 20 Хөвгүүд 20	2010.01.01 2011.12.31	Анхан шатны тэмцээнээс шалгарсан 1 баг оролцоно. /40+10+40/
18	Хөнгөн атлетик	100м, 200м, 400м, 800м, 1500м, 5000м	15-17 нас: Охид Хөвгүүд	2008.12.31 2010.01.01	Анхан шатны тэмцээнээс 1-р байр эзэлсэн баг, тамирчид оролцоно Нэг тамирчин буухиа гүйлтээс гадна 2 зайд оролцож болно.
		Уртын харайлт			
		Өндрийн харайлт			
		Гурвын харайлт			
		Бөөрөнцөг түлхэлт			
		Зээрэнцэг шидэлт			
		4x100м	Охид 4 Хөвгүүд 4		
4x400м	Охид 2 Хөвгүүд 2				
19	Хүндийн өргөлт	45кг, 50кг, 56кг, 60кг, 65кг, 71кг, 79кг, 88кг, +88кг	14-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2011.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		40кг, 44кг, 48кг, 53кг, 58кг, 63кг, 69кг, 77кг, +77кг	Охид		
20	Чөлөөт бөх	45кг, 48кг, 51кг, 55кг, 60кг, 65кг, 71кг, 80кг, 92кг, 110кг	15-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		Сонгомол 65кг, 71кг, 110кг			
		40кг, 43кг, 46кг, 49кг, 53кг, 57кг, 61кг, 65кг, 69кг, 73кг	Охид		

21	Ширээний теннис	Ганцаарчилсан	15-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс 1-р байр эзэлсэн баг, тамирчид оролцоно.
		Холимог хос			
		Багийн төрөл	15-17 нас: Охид 2 Хөвгүүд 2		
22	Жюү жицү	48кг, 52кг, 56кг, 62кг, 69кг, 77кг, 85кг, +85кг	15-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		40кг, 44кг, 48кг, 52кг, 57кг, 63кг, 70кг, +70кг	Охид		

#### 6.3.4. Үзүүлэх тоглолт:

д/д	Спортын төрөл	Ангилал	Тамирчдын тоо, насны хязгаар	Насны ангилал /он, сар, өдөр/	Шигшээ тэмцээнд оролцох тамирчдын тоо, хугацаа (ангилал тус бүрд)
1	Модон барилдаан	55кг, 65кг, 75кг, +75кг	15-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		50кг, 60кг, 70кг, +70кг	Охид		
2	Электрон спорт (е-спорт)	Valorant 5vs5	15-17 нас: хүйс харгалзахгүй 6	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс шалгарсан 1 баг оролцоно.
3	Холимог тулаан	47.6кг, 52.2кг, 56.7кг, 61.2кг, 65.8кг, 70.3кг, 74.8кг, 79.4кг, +79.4кг,	15-17 нас: Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс жин тус бүрд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		44.1кг, 47.6кг, 52.2кг, 56.7кг, 61.2кг, +61.2кг	Охид		
4	Дуатлон	Ганцаарчилсан (2.5км гүйх-10км дугуй-1.25км гүйх)	15-17 нас: Хөвгүүд Охид	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнд 1-р байр эзэлсэн тамирчин оролцоно.

#### 6.3.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын зуны төрөл:

д/д	Спортын төрөл	Ангилал	Тэмцээний зай, тоо насны хязгаар	Насны ангилал /он, сар, өдөр/	Шигшээ тэмцээнд оролцох тамирчдын тоо, хугацаа (ангилал тус бүрд)
1	Пара хөнгөн атлетик	T11	15-17 нас: Охид 200м Хөвгүүд 400м	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс зай тус бүрд 1,2-р байр эзэлсэн баг, тамирчин оролцоно.
		T12, 13			
		T37, 38	15-17 нас: Охид 100м Хөвгүүд 200м		
		T46	15-17 нас:		

		T53, 54, 55, 56	Охид 400м Хөвгүүд 400м		
		F57, 58 бөөрөнцөг	15-17 нас: Охид 2кг		
		F40,41 зээрэнцэг	Хөвгүүд 2кг		
		F32, 33, 34, 51 модон саваа	15-17 нас: Охид 397гр		
			Хөвгүүд 397гр		
2	Хонхот бөмбөг	Баг: (хараагүй)	15-17 нас: Охид 6 Хөвгүүд 6	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс шалгарсан 1 баг оролцоно.
3	Пара бочи	BC1	15-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс ангилал тус бүрд 1,2-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		BC2			
		BC3			
		BC4			
4	Диф даам	Ганцаарчилсан	15-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс төрөл тус бүрд 1,2-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
5	Диф сагсан бөмбөг 3x3	Баг	15-17 нас: Охид 4 Хөвгүүд 4	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс шалгарсан 1 баг оролцоно.
6	Тусгай хөнгөн атлетик	L1, L2 (100м)	15-17 нас: Охид Хөвгүүд	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс зай тус бүрд 1,2-р байр эзэлсэн тамирчин оролцоно.
		L1, L2 (200м)			
7	Тусгай хамтарсан хөл бөмбөг	Баг	15-17 нас: Охид 11 Хөвгүүд 11	2008.01.01 2010.12.31	Анхан шатны тэмцээнээс шалгарсан 1 баг оролцоно. (Баг: Үндсэн тоглогч 6, дэмжин тоглогч 5 тамирчин оролцоно)

#### Долоо. Тамирчдад тавигдах шаардлага

7.1.Тамирчид нь сахилга баттай, эерэг харилцаа, хандлагатай, мэндлэх, хүндлэх, талархах зэрэг ёс зүйн хэм хэмжээг баримтална.

7.2.Баг, тамирчид нь Зохион байгуулах хороо, спортын холбоод, шүүгч, дасгалжуулагч, сайн дурын ажилтны тавьсан шаардлагыг биелүүлж, наадмын арга хэмжээнд нэгдсэн зохион байгуулалтад орж, дэг журамтай оролцоно.

7.3.Тамирчин өрсөлдөгч нараа хүндэтгэн, шударга өрсөлдөөнийг үзүүлнэ.

7.4.Наадмын нэгдсэн зааврын 6.3, 9.1 дэх хэсэгт тус тус заасан тамирчны насны хязгаарыг зөрчсөн тохиолдолд тухайн тамирчныг шигшээ тэмцээнээс хасаж, гаргасан амжилтыг хүчингүйд тооцож, дараагийн байр эзэлсэн тамирчинд шилжүүлнэ.

## Найм. Эмнэлэг хяналт, аюулгүй ажиллагаа

8.1. Наадамд оролцогч байгууллага өөрийн нэрийн өмнөөс оролцох баг, тамирчдаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, үзлэгийн “зөвшөөрсөн” тэмдэглэгээг эмчийн гарын үсэг, тамгаар баталгаажуулж авчирна.

8.2. Аюулгүй байдлыг хамгаалах хэрэглэл, хэрэгслийг тэмцээнд оролцох тамирчдад стандарт, дүрмийн дагуу (зориулалтаар хэрэглэхийг тамирчин, хариуцсан дасгалжуулагч, багийн ахлагчаас) шаардана.

## Ес. Цахим бүртгэл, хугацаа, мандат олголт

9.1. Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороо нь наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөл, ангилал, зайд тамирчдыг оролцуулахдаа Биеийн тамир, спортын цахим систем ([cpanel.sport.gov.mn](http://cpanel.sport.gov.mn))-д нэвтэрч тамирчны регистрийн дугаар, хувь хүний мэдээллийг ашиглахыг зөвшөөрч мэдүүлгийг үнэн зөв илгээнэ.

9.2. Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороо нь анхан шатны тэмцээнд оролцох өөрийн тамирчдаа [www.sport.gov.mn](http://www.sport.gov.mn) цахим мэдээллийн сангийн тэмцээн, наадмын системийн бүртгэлд бүртгэн анхан шатны тэмцээний үр дүнгийн мэдээллийг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс нээж 2025 оны 04 дүгээр сарын 29-ний дотор оруулсан байна.

9.3. Наадмын оролцох баг, тамирчдын гэрээ, цахим мэдүүлгийг үндэслэн Засаг захиргааны нэгжийн дагуу аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага болон спортын холбоо нь тамирчдын нэрээр ирүүлэх мэдүүлгийг салбарын нэгдсэн цахим сангийн бүртгэлээр дамжуулан мандатын бүртгэл хийнэ.

9.4. Шигшээ тэмцээний цахим бүртгэл нь 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 08:30 цагт эхэлж, 2025 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 22:00 цагт хаагдана.

9.5. Наадмын шигшээ тэмцээнд оролцох баг, тамирчдын анхан шатны тэмцээний үр дүн, цахим гэрээ, нэрээр ирүүлсэн мэдүүлгийг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 09:00 цагаас эхлэн баг, тамирчдын баталгаажсан мэдээллийг Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хорооны албаны цахим шуудангийн хаягаар илгээнэ.

9.6. Наадмын хөтөлбөрт багтсан спортын төрөлд оролцох баг тамирчид наадмын мандатын ажлын хэсэгт тэмцээний хөтөлбөрт заасан техникийн зөвлөгөөнөөс өмнө мандатын баталгаажилтыг хийлгэснээр тэмцээнд оролцох эрх үүснэ.

9.7. Аймаг, дүүргийн болон спортын холбооны цахим бүртгэл хариуцсан админ нь наадамд оролцох баг, тамирчид, дасгалжуулагч, албаны төлөөллийн бүртгэлийг тэмцээн наадмын системийн цахим бүртгэлийн хугацаанд нэгэн адилаар бүртгэж мандат олгоно.

## Арав. Маргаан таслах

10.1. Тэмцээнд оролцох баг, тамирчид маргаантай асуудлаар тэмцээний ерөнхий шүүгчид хүсэлт, гомдол гаргах эрхтэй бөгөөд тухайн спортын холбооны шүүгчийн зөвлөл шийдвэрлэнэ.

10.2. Хүсэлт, гомдлыг зөвхөн тухайн аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар хорооны эрх бүхий албан тушаалтан багийн нэр, хаяг, гарын үсгээр баталгаажуулж тэмцээний ерөнхий шүүгчид бичгээр хандана.

10.3. Цахим бүртгэлтэй холбоотой гаргасан хүсэлт, гомдол нь үндэслэлтэй байх шаардлагатай бөгөөд Зохион байгуулах хороо шийднэ.

10.4. Тэмцээний үр дүнг спортын холбоодоос баталгаажуулалт хийгдэж, Зохион байгуулах хороонд ирүүлсний дараа ямар нэгэн хүсэлт, гомдол хүлээж авахгүй болно.

## Арван нэг. Наадмын сурталчилгаа

11.1. Биеийн тамир, спортын улсын хороо болон Аймаг, дүүргийн биеийн тамир, спортын газар, хороод, спортын холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагын пэйж хуудас, веб сайт, шторк, хулдаасан хэвлэл, рийл, шууд дамжуулалт, лайв, тэмцээний үеийн явцын мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээлж, түгээн сурталчилна.

## Арван хоёр. Шагнал, урамшуулал

12.1. Наадмын шигшээ тэмцээний төрөл тус бүрд эхний гурван байр эзэлсэн баг, тамирчид, дасгалжуулагчдад Монголын хүүхдийн спортын зуны VIII наадмын медаль, өргөмжлөл, Засгийн газрын 2018 оны 173 дугаар тогтоолын дагуу мөнгөн шагналыг олгоно.

12.2. Оролцогч байгууллагыг медалийн чанараар байр эзлүүлж цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

12.2.1. Аймгийн Биеийн тамир, спортын газраас байгууллагын дүнгээр эхний 6 (зургаа) байр үндсэн төрөлд эзлүүлэн цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Нэгдүгээр байр: Цом, өргөмжлөл, 6 сая

Хоёрдугаар байр: Цом, өргөмжлөл, 5 сая

Гуравдугаар байр: Цом, өргөмжлөл, 4 сая

Дөрөвдүгээр байр: Цом, өргөмжлөл, 3 сая

Тавдугаар байр: Цом, өргөмжлөл, 2 сая

Зургаадугаар байр: Цом, өргөмжлөл, 1 сая

12.2.2. Дүүргийн Биеийн тамир, спортын хорооноос байгууллагын дүнгээр эхний 3 (гурав) байр үндсэн төрөлд эзлүүлэн цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

Нэгдүгээр байр: Цом, өргөмжлөл, 6 сая

Хоёрдугаар байр: Цом, өргөмжлөл, 5 сая

Гуравдугаар байр: Цом, өргөмжлөл, 4 сая

12.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн спортын төрөлд медалийн чанараар амжилт гаргасан Аймаг, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хорооноос байгууллагын дүнгээр эхний 3 (гурав) байр эзлүүлэн цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

12.2.4. Спортын төрөл тус бүрд байгууллагын дүнг гаргаж, эхний 3 (гурав) байр эзлүүлэн медаль, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

---oOo---